



Хүнсний гол нэрийн барааны үнэ


2019 оны 7-р сарын 03-ний байдлаар

2019 оны 7-р сарын 03-ний байдлаар гол нэрийн барааны үнэ өмнөх сараас 1.0 хувь, өмнөх 7 хоногоос 0.8 хувиар буурсан байна.

Махны дундаж үнэ: 2019 оны 7-р сарын 03-ний байдлаар үхрийн ястай махны үнэ өмнөх сараас 5.1 хувь, үхрийн цул махны үнэ 3.6 хувиар өсч, хонины ястай махны үнэ 2.9 хувь, ямааны ястай махны үнэ 3.7 хувь, адууны ястай махны үнэ 0.1 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногоос үхрийн ястай махны 5.9 хувь, үхрийн цул махны үнэ 3.2 хувиар өсч, хонины ястай махны үнэ 2.9 хувь, ямааны ястай махны үнэ 1.2 хувь, адууны ястай махны үнэ 0.1 хувиар буурсан байна.

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ, төгрөг




2019 оны 7-р сарын 03-ний байдлаар 1 кг үхрийн цул мах 14737 төгрөг, үхрийн /ястай/ мах 12304 төгрөг, хонины /ястай/ мах дунджаар 10132 төгрөг, адууны /ястай/ мах 9058 төгрөг, ямааны /ястай/ мах 8399 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

Гурилын үнэ: 2019 оны 7-р сарын 03-ний байдлаар гурилын үнэ өмнөх сараас дээд зэргийн савласан гурилын үнэ 3.1 хувь, 1-р зэргийн савласан гурилын үнэ 2.9 хувь, 2-р зэргийн савласан гурилын үнэ 1.1 хувиар өсч, дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ 1.4 хувиар буурчээ.

Өмнөх 7 хоногоос дээд зэргийн савласан гурилын үнэ 3.1 хувь, 1-р зэргийн савласан гурилын үнэ 1.9 хувь, 2-р зэргийн савласан гурилын үнэ 1.1 хувиар өсч, дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ 1.4 хувиар буурчээ.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2019 оны 7-р сарын 03-ний байдлаар цагаан будаа, элсэн чихрийн үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ, төгрөг



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2019 оны 7-р сарын 03-ний байдлаар төмс, хүнсний ногооны үнэ өмнөх сараас луувангийн үнэ 9.1 хувь, төмсний үнэ 7.7 хувь, хүрэн манжингийн үнэ 5.6 хувиар өсч, байцааны үнэ 12.2 хувиар буурч, сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногоос луувангийн үнэ 10.6 хувь, төмсний үнэ 7.1 хувь, хүрэн манжингийн үнэ 6.8 хувиар өсч, байцааны үнэ 8.3 хувиар буурч, сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цэцгийн тосны дундаж үнэ: 2019 оны 7-р сарын 03-ний байдлаар өмнөх сараас задгай сүүний үнэ 27.2 хувиар буурч бусад сүүний үнэ өөрчлөлтгүй байна. Өмнөх 7 хоногоос задгай сүүний үнэ 26.5 хувиар буурч бусад сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Цэцгийн тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос 11.5 хувиар буурсан байна. Ургамлын тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос 0.5 хувиар өсчээ. Өндөгний үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос 0.6 хувиар өссөн байна.

**ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газар
2019 оны 7-р сарын 03**